



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/466

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 4 нэгж талбарын газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрыг зориулалтын дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг тус тус шилжүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны а/410 дугаар захирамжийн хавсралтын А.Буянжаргалтай холбогдох заалт, 2021 оны А/359 дүгээр захирамж, сумын Засаг даргын 2014 оны А/20 дугаар захирамжийн хавсралтын Б.Эрдэнэжаргалтай холбогдох заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/429 дүгээр захирамжийн хавсралтын С.Хишигдоржтой холбогдох заалт, 2021 оны А/330 дугаар захирамжийн Х.Лхавгасүрэнтэй холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100989

D:My Doc. Zahiramj. Zasag darga



Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дугаар сарын 09-ны өдрийн 1/46 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД
ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ²	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	А.Буянжаргал	ЙП89051810	Амины орон сууц	О.Пүрэвдорж	ЙК92111212	Амины орон сууц	586	13 дугаар баг, Төв-2 гудамж, 213 тоот	20 жил
2	Б.Эрдэнэжаргал	ЙЮ77011900	Гэр, орон сууцны хашааны газар	Б.Баатар	ЙЮ86020419	Гэр, орон сууцны хашааны газар	840	13 дугаар баг, Өгөөмөр-7 гудамж, 700 тоот	30 жил
3	С.Хишигдорж	ЙГ88011719	Амины орон сууц	Н.Бямбасүрэн	ЙР85090722	Амины орон сууц	400	5 дугаар баг, 2 дугаар гудамж, 17 тоот	18 жил
4	Х.Лхавгасүрэн	ЙП94022301	Амины орон сууц	Ж.Амарцэцэг	УП89030945	Амины орон сууц	484	13 дугаар баг, Дөл-9 гудамж, 902 тоот	30 жил

